

Агуулга

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж байгууллага	3
1.3. Төслийн тойм байршил, тойм зураг	3
1.4. Төслийн төлөвлөлт	5
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
БҮЛЭГ 3 . ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	11
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 11. 2025 ОНЫ БОМТ-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	25
ДҮГНЭЛТ	26

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг	3
Зураг 2. Төсөл хэрэгжих газрын төрх байдал	4
Зураг 3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хяналтын цэгүүдийн зураг	22

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн байршилын координат	3
Хүснэгт 2. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь	9
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12

Хүснэгт 4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 6. Осол эрсдэлийг бууруулах,урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	21
Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
Хүснэгт 9. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	25
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	27

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Дорноговь аймгийн Хатагбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах “Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)

1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж байгууллага

“Говийн мөнгөн жолоо”ХХК, Улсын бүртгэлийн дугаар : 0611008129, регистрийн дугаар: 3320758, газрын гэрчилгээний дугаар: 000008088


1.3.Төслийн тойм байршил, тойм зураг

Тус гаалийн хяналтын талбай нь Дорноговь аймаг, Хатанбулаг сум, 3-р баг, 30 га талбайд байрлаж байна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн байршилын координат

№	Уртраг	Өргөрөг	Нийт талбай
1	109.937523	42.723792	30 га
2	109.943552	42.719548	
3	109.939845	42.716685	
4	109.933816	42.720928	

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг



Зураг 2. Төсөл хэрэгжих газрын төрх байдал





1.4. Төслийн төлөвлөлт

“Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн гаалийн хяналтын бүс нь нийт 30 га талбайтай бөгөөд үүнээс 20-г нүүрс ачилт буулгалтын талбайн болгон ашиглах ба үлдсэн 10 га дээрээ ажилчдын байр, завсарын газар зэрэг бусад барилга байгууламжийг барина. Ачилт буулгалтын талбай нь 1.000.000 тонн нүүрс хадгалах хүчин чадалтай бөгөөд өдөрт 100 том өврийн машин буюу ойролцоогоор 6500 тонн нүүрс буулгах боломжтой.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл

Дорноговь аймгийн Хатанбулаг сум нь 1924 онд байгуулагдсан. Хуучнаар Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу. Халив баг 144 өрх, 405 хүн, Эргэл баг 109 өрх, 431 өрх, Агаруут баг 166 өрх, 539 хүн, Амна-Ус 189 өрх, 574 хүн, Сулинхээр баг 174 өрх, 614 хүн, Замын шанд баг 128 өрх, 356 хүн амтай. Нийт 6 багийн 910 өрхөд 2919 хүн амьдардаг. Далайн түвшнээс дээш 900-1400 м өргөгдсөн. Төв Азийн их цөл, өндөрлөгийн умард хаяанд байрладаг. Газар хөдлөлийн идэвхитэй бүсэд оршдог. Сумын нутаг дэвсгэр нь уул гүвээ толгод бүхий заримдаг цөлийн бор саарал, цайвар бор, хужир мараат хөрстэй, хялгана, харганат цөлийн хээр алаг өвст ургамалтай, байгалийн хээржүү цөлд хамаарна. Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэр нь физик газарзүйн мужлалаар Говийн их мужийн Дорноговийн мужийн Хатанбулагийн талархаг газрын тойрогт багтана. Тус сумын нутаг цав толгод бүхий бага зэргийн долиорхог тэгш талтай, тэдгээрийн дунд хотос, хонхор газар, тойром тохиолдоно.

Уур амьсгал

Хатанбулаг харуул нь аймгийн төвөөс баруун урд зүгт 240 км зайд далайн түвшнээс дээш 1007 метр өндөрт оршдог. Төсөл хэрэгжих орчинд зарим хэсэгтээ говийн намхавтар уулсаар хүрээлэгдэж ухаа, гүвээ, толгод энд тэнд үргэлжилнэ. Хотгор, гүдгэрийн энэхүү нөхцөл нь эндхийн уур амьсгал бүрэлдэн тогтох нэг онцлог болдог. Энэ орчмын уур амьсгалын нөхцөл нь хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц ижил, зун нь халуун, өвөл нь харьцангуй дулаавтар, хавартаа салхи, шуурга болон хуурайшилтын байдгаар илэрнэ.

Төсөл хэрэгжих орчинд ойрын уулсгүй, хөндий тал учраас нарны халхагдал байгатай байна. Энд жилийн нарны гийгүүлэл нь боломжит хугацааны 72%, хүйтэн улиралд 72-78, буюу нар жилд 3200 цаг гийгүүлнэ.

Хөрсний өнгөн гадаргын жилийн дундаж температур +8.3 °C байх бөгөөд зөвхөн XI-II сард сөрөг / -5°C-аас 15°C/, III-X сард эерэг / +4.3 °C-аас 28°C/ утгатай байна. Хөрсний гадаргад үнэмлэхүй их халуун 6-8 дугаар сарын халуун өдрүүдэд 63 °C, үнэмлэхүй хамгийн бага цасан бүрхүүлтэй өвлийн хүйтэн өдрүүдэд -37°C хүрч, үнэмлэхүй агууриг 100 °C болдог нь хөрсний уур амьсгалын хувьд гол шинж “хахир” нөхцөл юм.

Өвлийн улиралд баруун өмнөөс хойд зовхисын чиглэл ноёлж, Улаан нуурын хотгор, хөндийн дагуу баруун өмнөөс /18.3%/ , баруун хойноос / 12.2-12.7%/ салхилна. Хавар 4 дүгээр сард баруун өмнөөс баруун хойд зовхисын салхи/15-27.7%/ ноёлно. Зун 7 дугаар сард салхины ноёлол зүүн өмнөөс 20%, баруун хойноос 21% , хойд, өмнө, баруун өмнөдөөс 8-17%, намар 10 дугаар сард салхины ноёлох чиглэл баруун өмнөөс хойд 16-27%, зүүн өмнөөс 11.4% тус тус байх бөгөөд хотгор гүдгэрийн хэв шинжтэй байна. Нэгдүгээр сард зүүн өмнөөс баруун хойд зүгийн салхи бусад зүгийн салхинаас 2 дахин их 4.6-6.7 м/с, 4 дүгээр сард ноёлох зүгийнх 7.3-8.5 м/с, намар 10 дугаар сард 4.2-6.1 м/с байна.

Тус бүс нутагт 15м/с –ээс их салхитай 10 өдөр, шороон шуурга 33 өдөр, цасан шуурга 10 өдөр тохиолдож, салхины их хурд 16-34 м/с, ялангуяа хаврын саруудад 28-34 м/с хүрнэ. Нүүрс ачих буулгах талбайн үйл ажиллагаа болон ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөл нь тухайн бүс нутгийн бичил уур амьсгал, цаг агаарын онцлогтой салшгүй уялдаа холбоотой байна.

Гадаргын ус

Сумын нутаг дэвсгэрт байнгын урсацтай гадаргын усны эх булаг байхгүй бөгөөд хааяа ордог борооны усаар тэжээгддэг хужиртай шал тойром хэд бий. Эдгээрээс ус хураах талбайн хэмжээгээр арай том нь Сэвхүүлийн тойром болно. Жилд дунджаар 100-150мм тунадасорох бөгөөд ихэнх нь ууршилтанд зарцуулагдаж өчүүхэн хэсэг нь хөрсний усыг тэтгэдэг онцлогтой. Гадаргын түр урсацын модуль 0.003л/с*км², жилийн нөөцийн хувийн нэгж 0.1 мян. м³/км² байна. Хур бороо орох үед хуурай сайруудаар түр урсац буй болж зарим хэсэг нь хөрсөнд шингэж үлдэх хэсэг нь шал тойромд хуримтлагдан говийн наранд халж амархан ууршин алга болдог.

Гадаргын доорх ус

Судалгааны талбай нь физик-газарзүйн байрлалын хувьд Ш.Цэгмидийн ангиллаар Дорноговийн талархаг мужийн цөлөрхөг дэд хэсэгт хамрагдана. Хатанбулаг орчимд өрөмдлөг-геофизикийн судалгаагаар илрүүлсэн уст үе нь бага ундаргатай (1.0-1.5 л/с), усны чанар нь муу байна.

Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их Говийн мужийн Өргөргийн бүсийн хээржүү цөлийн бор саарал хөрсний хэв шинжит тойрогт багтдаг. Эндхийн хөрс нь нам уул, ухаа толгод, тал хотгор, жижиг цав толгодын хээржүү цөлийн бор, хээржүү цөлийн мараалаг саарал хөрс тархсан. Төслийн талбайн хөрс нь сул хүчиллэг, дээж 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор (P₂O₅) 1.2 мг буюу бага, кали (K₂O) 13 мг буюу бага, шингээгдсэн сууриудын нийлбэр (Ca₂+Mg₂) нь 16.8 мг-экв буюу шингээх багтаамж хангалттай, ялзмагийн хэмжээ 0.75 % байгаа нь шим тэжээлийн хангамж маш бага байна. Хөрсний эвдрэлийн хувьд бэлчээрийн даац хэтэрхэд ус салхинд эвдрэх аюултай. Төсөл хэрэгжих орчимд үүсч тархсан хөрс нь байгалийн үржил шимээрээ тааруу, ус барих чадвар султай, элсэнцэр, элсэн механикийн бүрэлдэхүүнтэй учраас салхинд тэсвэр муутай юм.

Ургамлан нөмрөг

Ургамал газарзүйн мужлалтаар Хуурайдуу хэв шинжийн Тал, талархуу газрын бүсийн ургамалжил бүхий мужлалын хүрээнд Дорноговь Азийн Улз-Хэрлэнгийн хөрсний тойрогт орно. Төслийн талбайд Агь-хазаар өвс-говийн хялганат, таана-говийн хялганат, хазаар өвс-говийн хялганат, баглуур-таана-говийн хялганат бүлгэмдэл бүхий 5-10% бүрхэцтэй цөлөрхөг хээрийн ургамалшилтай байна. Зүйлийн бүрдлийн хувьд сайрын хялгана, цулхир, говийн хялгана, өргөст лууль зохилно.

Амьтны аймаг

Зөвхөн Хатанбулаг сумын болон төлөвлөж буй Гаалийн хяналтын талбай орчмын амьтны аймгийг ялгаж тодорхойлох нь учир дутагдалтай бөгөөд үүнийг амьтны аймгийн төрөл зүйлийн талхарлтын бүс нутгийн хэмжээнд авч үзэх нь оновчтой болох юм. Хатанбулаг орчмын газар нутгийн ан амьтад нь монгол орны амьтны газар зүйн хуваарилалт (зоогеографийн мужлал)-аар Уулархаг Азийн доод мужийн Монгол Түвдийн провинц, говийн дэд провинцийн хойд говийн тойрогт багтана. Хойд говийн тойргийн онцлог нь говийн бүсийн бүх нутгийн бүх нутгийг хамардаг учраас амьтны аймаг нь говийн ба зарим талаараа хээрийн амьвдаас бүрддэг. Энд мэрэгчдээс сохдой оготно, монгол чичүүл, бозлог зурам, монгол даахай, хөх цомч, урт сүүлт шишүүхэй, Сибирийн алаг даага, туурайтнаас хар сүүлт зээр, хулан, махчдаас өмхий хүрэн, хярс, үнэг зонхилдог.

БҮЛЭГ 3 . ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн “Гаалийн хяналтын талбай төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, газар дээр нь судлагаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтийг өртөгдөх байгалийн үндсэн тусагдахуун нь хөрс, газар эдэлбэр, агаар, усан орчин юм. Төслийн талбайд учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойлж доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 2. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
Агаар орчин			
Тоосжилт	Нүүрс ачиж буулгах явцад тоожиолт үүснэ. Мөн засмал замаас талбай хүртэлх тээвэрлэлт болон нүүрсний овоолгын салхины элэгдлээр үүсэх тоос	Тархах хамрах хүрээ хязгаарлагдмал	
Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийн, утаа. Угаар	Автомашин	Агаар бохирдуулагч цэгэн эх үүсвэр болох ба хадгалагдах тархах хүрээ хязгаарлагдмал	
Усан орчин			
Хатуу болон шингэн хог хягдал	Ахуйн болон шатах тослох материалын хягдал, Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас үүсэх аливаа хог хаягдал шатах тослох материал асгарах, гоожих	Шатах тослох материал асгарснаас хөрс хөрсний ус бохирдож болзошгүй, Хур борооны усаар аливаа хог хаягдал асгаралт угаагдаж хөрсний ус бохирдуулж болзошгүй	
Хөрсөн бүрхэвч			
Хөрсний бохирдол	Тээврийн хэрэгслээс ялгарч буй хорт нэгдэл, хог хаягдал бохир ус	техникийн хэрэгслийн шатахуун, тос асгаралтаас хөрс хөрсний ус бохирдож болзошгүй Хөрсний бохирдлоос хөрсний микробиологийн шинж чанар алдагдах	
	Гаалийн хяналтын талбай орчим нь сийрэг, элсэнцэр бүтэцтэй байгаа нь ус нэвтрүүлэх чадвар өндөртэй учир хөрсөнд ямар нэг уусамтгай болон шингэн хаягдал алдагдсан тохиолдолд хурдан нэвчиж тархах аюултай		

	Механик үйлчлэлээр (машины дугуй, хүний хөл) хөрс талхагдаж сийрэгжих, нимгэрэх	
	Ухсан газарт ландшафтийн эвдрэл үүсч, хөрсний генитик үе давхаргууд холилдон морфологи тогтоц бүр мөсөн алдагдах	
	Хөрс салхинд хийсч элэгдэж эвдрэх үйл явц нь ихсэн тоосжилт нэмэгдэх	
Ургамлан бүрхэвч		
Ургамлын талхагдал	Төслийн талбайн бүс орчмын ургамлан нөмрөгийн биомассын нөөц хомстох, талхагдах Авто зам орчмын ургамлан бүрхэц сийрэгжих ,	Хэмжээ хязгаарлагдмал ба ургамалжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой
	Талбайг барьж байгуулах явцад ашиглагдах хурдас чулуулаг, барилгын материал, техник тоног төхөөрөмжийн хог хаягдлаар эрүүл ургамалан нөмрөгтэй газар дарагдах	
	Эвдэрч доройтсон ургамлан нөмрөгт хог ургамлын зүйлийн тоо нэмэгдэх	
	Авто зам орчмын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсэх	
Бохирдол	Ахуйн хог хаягдал болон шатах тослох материалын алдагдал	Ургамлын биомассын хэмжээ багасах, ургамлан нөмрөг устгах, эвдэрч доройтсон ургамлан нөмрөгт хог ургамлын зүйлийн тоо нэмэгдэх

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн Гаалийн хяналтын талбай төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу, мөн сайдын 2014 оны 4-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримтласан бөгөөд төслийн онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд багтах дүйцүүлэн БОМТ-д багтах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр багтсан бөгөөд төслийн 2025 оны БОМТ-ний ажилд нийт **12 686 000төгрөг** зарцуулахаар төлөвлөв.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд 2025 онд хийхээр төлөвлөгдсөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн ажлын явцад үндэслэн боловсрууллаа.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8	9
Агаар орчин									
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр агаар бохирдох	Замын усалгаа хийх	Нийт эдэлбэр талбайд	удаа	200.0	12	2400.0	2025 он	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ
		Ажилчдын байрлах байрны халаалтыг дэвшилтэт технологийн ашиглана шийдвэрлэх	Агаарын чанарт нөлөөлөхөөс сэргийлэх	Бүтээн байгуулалтын зардлаар				2025 он	
		Зонхилох салхин талд ногоон хөшиг байгуулах	Тоосжилтыг бууруулах	Ногоон байгууламжийн зардлаар				2025 он	

Хөрсөн бүрхэвч, газрын гадарга									
2	Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Талбайн орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн сүлжээтэй болж, тэмдэг тэмдэглэгээг сайжруулах	Гаалийн бүсийн гаднах замын маршрут	ш	150.0	3	450.0	2025 он	Хөрс хамгаалах цөлжилтөөс хамгаалах хууль, “Газрын төлөв байдал хяналт баталгааг хийх журам” бусад холбогдох аргачлал
Усан нөөц, чанар									
3	Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах	Унд ахуйн худагт тоолуур суурилуулах	Унд ахуйн худагт	удаа	800.0	1	800.0	2025 он	Ус ашиглалтын хэрэглээг тоолууржуулт журам, Усны тухайн хууль MNS
		Усны нөөц ашигласны төлбөр төлөх	Тоолуурын заалт	Тоолуурын заалтын дагуу				2025 он	

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах “ Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн “ Гаалийн хяналтын талбай” байгуулах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2025 он

		Ус ашиглуулах дүгнэлтийг Галба-Өөш долоодын говийн сав газарт гаргаж, аймгийн байгаль орчны газраас зөвшөөрөл авч гэрээ байгуулан ажиллах	Усан хангамж					2025 он	6148:2010 “Усны чанар. Газар доорх усыг бохирдуулагч бодисын “ЗДХ” MNS4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
		Усны хэмнэлтэй ашиглах тухай анхааруулах хуудас санамжийг байрлуулах	Гаалийн хяналтын бүсэд	ш	25.0	15	375.0	2025 он	
Нийт							4025.0		

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлага юм. “Гаалийн хяналтын бүс” ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан моджуулах, зүлэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулав.

Хүснэгт 4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээ нэмэгдүүлэх	Мухар эрэг булгийн эхийг хамгаалж мод тарих	Мухар эрэг булгийн эхийн зүүн урд хэсгээр	ш	100	10.0	1000.0	Жилийн хавар намрын улиралд	Газрийн тухай хууль Тэрбум мод үндэсний хөтөлбөр
		Ажилчдын тосгоны сул талбай ногоон байгууламж байгуулах	Хайлаас тарих	Ш	25	10.0	250.0	Нөхөн сэргээлт хийх	
			Жигд тарих	ш	25	5.0	125.0		
		Арчилгаа, усалгааны зардал	Ногоон байгууламж	жил	1	800.0	800.0	2025	
Нийт							2175.0		

БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн төлөвлөгөөний дагуу одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн Гаалийн хяналтын талбай төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал болон, төслийн дараах үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын төвлөрсөн цэгийг байгуулахын тулд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдал хадгалах зориулалтын цэг, хог хаягдлыг ангилан ялгах сав, өдөр тутмын цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг өдөр болгон зайлуулах.

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хаягдал	Хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшүүлэх	Төслийн хүрээнд	-	-	-	-	тогтмол	Хог хаягдлын тухай хууль Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт
2		Бие засах газрын ариутгал халдваргүйжүүлэлтийг сар бүр хийх	Түр хогийн цэг	ш	50.0	10	500.0	Төсөл хэрэгжих хугацаанд жил бүр	

		Хог хаягдлыг ангилан ялгаж ач холбогдлыг таниулах сургалт зохион байгуулах	Нийт ажилчид	-	200.0	1	200.0	Жилд 1 удаа	тавигдах шаардлага ЭМСайдын 2014.06.02-ны өдрийн 187-р тушаалын 2-р хавсралт
		Зам дагуу унасан нүүрсний хаягдал болон ахуйн хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн хог цэвэрлэх өдөртэй болох	Нийт ажилчид				300.0.	Жилд 2 удаа	Ариутгал халдваргүйтгэх шавж мэрэгч устгах бодисыг хэрэглэх, хадгалахад мөрдөх журам
3	Аюултай хог хаягдал	Ашигласан тос масло цуглуулах цэг байгуулах	Машин техникийн засварын хэсэгт		500.0				
4	Ахуйн хаягдал	Хог хаягдлыг зайлуулах мэргэжлийн байгууллагатай гэрээ хийх	Төслийн хүрээнд	Гэрээний дагуух төлбөр				Сар бүр	
Нийт						1500.0			

БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс Авто зогсоол, засварын газар, кемп нь 2025 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Мөн галын аюулгүй байдлын хор байршуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 1000 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 6. Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1. Хөдөлмөр хамгаалал								
1.1	Гэнэтийн аваар осол хөдөлмөр хамгааллын зөрчил илрэх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчид	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	-
2. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх								
2.1	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах Аянга цахилгаан, хэт халалт, хээрийн түймэр, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах.	Төслийн талбайд	2		500.0	2025 он	MNS5078-2001, MNS 5390:2004,

**Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах “ Говийн
мөнгөн жолоо” ХХК-ийн “ Гаалийн хяналтын талбай” байгуулах төслийн 2025
оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2025 он

2.2	Төслийн үйл ажиллагаанд гал гарах	Галын салаа шинэчилж сайжруулах (Сарай, хүрз, багор дэгээ, шулуун лоом, хувин 2ш, сүх, жоотуу, хөрөө, СЕ ABC-4 галын хор 2ш, хорны уут 2ш, элсний хайрцаг, галын хөнжил)	Төслийн талбайд	1	1	500.0	-	-
		Нийт				1000.0		

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр “ Байгаль орчны менежментийг төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д заасан. Орчны хяналт шинжилгээний хүрээнд “Гаалийн хяналтын талбай”- гаас хөрсний 1 цэг, агаарын 1 цэг, усны 1 цэгийг тус тус тусгаж өгөв.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7
1	Хөрсний эрүүл ахуйн	Кемп, бие засах газар	9 сард	1	50.0	100.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990
2	Ундны усны бүрэн шинжилгээ	Ундны уснаас	9 сард	1	49.0	49.0	
3	Хөрсний ерөнхий хими	Кемп, зам	10 сард	1	49.0	98.0	
4	Агаар бохирдуулагч бодис	Зам, нүүрс ачиж буулгах талбай, Кемп		1	150.0	150.0	Агаарын чанрын стандарт MNS 4585:98, Агаар мандал, сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 3384:32
Нийт						397.0	

Зураг 3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хяналтын цэгүүдийн зураг

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ "ГОВИЙН МӨНГӨН ЖОЛОО" ХХК-ИЙН ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЭЖ АВАХ ЦЭГ



БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах , үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамран зохион байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөө арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2025 он			
			7-р сар			
1		2	3	4	5	6
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын араг хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөнө.		Төслийн хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр		Гүйцэтгэх захирал
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулна.	50.0	7-р сар			Төслийн менежер
3	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хуудас хувцас хэрэгсэл	Үйл ажиллагааны	Төсөл хэрэгжих хугацаанд			Компанийн захирал

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах “ Говийн
мөнгөн жолоо” ХХК-ийн “ Гаалийн хяналтын талбай” байгуулах төслийн 2025
оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2025 он

	болон болзошгүй галын ажилгүй ажиллагааны багаж хэрэгслээр хангана.	зардалд орсон		
4	Хатанбулаг сумтай хог хаягдлын гэрээ байгуулах	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан		Компанийн захирал
Дүн			1000.0	

БҮЛЭГ 11. 2025 ОНЫ БОМТ-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнахдаа 2025 оны 10 сард Дорноговь аймгийн Байгаль орчны газар болон Хатанбулаг сумын иргэдэд танилцуулна.

Хүснэгт 9. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6
1	Хатанбулаг сумын 3-р багийн иргэд	БОМТ хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлэх, тайлагнах	Төслийн гол болзошгүй сөрөг нөлөөллийг буруулах , осол, эрсдэлийн менежментийг төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	10 сард	Төслийн менежер	Багийн байр
2	Ажилчид					Гаалийн хяналтын талбайн оффис
3	Аймгийн БОГ-т	БОМТ хэрэгжилтийн тайланг	БОМТ хэрэгжилтийн тайланг аймгийн БОГ-аар дүгнүүлж БОУАӨЯ -аар батлуулах			Аймгийн БОАЖГ-т
4	БОУАӨЯ			11 сарын 1ний дотор	Төслийн менежер	-
5	БОУАӨЯ -ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	БОУАӨЯ -аар батлуулах	12 сарын 1ний дотор	Төслийн менежер	-
6	Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргаа	Ус ашиглалтын тайлан	Тухайн жилийн ус ашиглах дүгнэлт болон гэрээний дагуу хийсэн ажил, ашигласан усны тооцоо тайланг хүргүүлэх	10 сард	Төслийн менежер	-

ДҮГНЭЛТ

“Говийн мөнгөн жолоо” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Гаалийн хяналтын талбай төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

“Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн Гаалийн хяналтын талбай төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, орчны тохижилт, цэцэрлэгжүүлжлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөр багтсан.

Төслийн талбайд 2025 онд хийхээр төлөвлөгдсөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн ажлын явцад үндэслэн боловсрууллаа.. Тус төслийн төлөвлөгөөний дагуу одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллана.

“Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн гаалийн хяналтын талбай төслийн үйл ажиллагааны үйл явцад гарах хог хаягдал болон, төслийн дараах үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын төвлөрсөн цэгийг байгуулахын тулд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдал хадаглах зориулалтын цэг, хог хаягдлыг ангилан ялгах сав, мөн гаалийн хяналтын талбайгаас гарах өдөр тутмын цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг өдөр болгон зайлуулах.

“Говийн мөнгөн жолоо” ХХК-ийн 2025 оны орчны хяналт шинжилгээний хүрээнд уст 1 цэгээс усны ерөнхий химийн шинжилгээг авч шинжлүүлнэ. Хөрснөөс мөн 1 цэг, агаарын чанарын хэмжилт хийлгэх зэрэг шинжилгээнүүдийг авч шинжлүүлнэ. Орчны хяналт шинжилгээний зардалд 2025 онд 348 000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4025 000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2175.000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1500 000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	397 000
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1000 000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1000.000
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн оршин суугчдад тайлагнах	1000 000
Нийт дүн		10 097 000

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 10 097 000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 5 048 500 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 9.9.Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

28